



ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТАСРАЛТГҮЙ СУРГАЛТ (Монгол ба Олон улсад)

*Л.Оюунбилэг M.Sc
Эрүүл мэндийн хөгжлийн төв*

Нэг. Монгол улсад

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн (2011 он) 25.5-д “Резидент эмчээс бусад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг жил тутам тасралтгүй сургалтад хамрагдаж, багц цагаа бүрдүүлэн ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд таван жилийн хугацаагаар сунгана” гэж тусгасан байдаг.

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах тасралтгүй сургалт буюу багц цагийн богино хугацааны сургалт нь доорхи эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаа нь зохицуулагдан явагддаг байна:

- Эрүүл мэндийн тухай хууль 2011
- Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журам” 2018 он А/484
- Эрүүл мэндийн сайдын “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам” 2017 он А/337
- Эрүүл мэнд, спортын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2015 он 98
- Эрүүл мэнд, спортын сайд, сангийн сайдын хамтарсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 2015 он 97/56
- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын “Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай” 2018 оны А/29, 2019 оны А/165 зэрэг эрх зүйн баримтууд Эрүүл мэндийн тухай хууль, салбарын сайд, ЭМХТ –ийн тушаал, журамаар зохицуулагддаг.

Эрх зүйн баримт бичигт Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах үйл ажиллагааг ЭМЯ, ЭМХТ удирдан зохион байгуулдаг. Эрүүл мэндийн яам нь хууль эрх зүйн баримт бичиг, бодлого боловсруулах, төгсөлтийн дараах сургалтын журмыг хэрэгжүүлэн ЭМХТ-д техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлж ажилладаг. Эрүүл мэндийн яаманд Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл ажилладаг ба энэ нь төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган, шийдвэр гаргах үүрэгтэй ажилладаг. Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн ажлын алба нь ЭМХТ-ийн Хүний нөөцийн бодлого зохицуулалтын алба байдаг.

Тасралтгүй сургалтыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэргэдэх “Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөл авсан Эрүүл мэндийн байгууллага болон анагаах ухааны боловсролын байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоод эрхэлдэг. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэргэдэх Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөлийн хурлын шийдвэрээр 2015 онд 113 байгууллагын 603 сургалтын хөтөлбөрөөр давхардсан тоогоор нийт 114225 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 2016 онд 30 байгууллагын 593 сургалтын хөтөлбөрөөр давхардсан тоогоор нийт 65874 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 2017 онд 124 байгууллагын 1156 сургалтын хөтөлбөрөөр давхардсан тоогоор нийт 166560 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагаа 2000 оноос эхэлсэн ба Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь эмчлэх, эм барих, сувилах, эх барих, сэргээн засах гэсэн төрөлтэй байдаг.

2015 оны 98 дугаар журамд зааснаар Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий уламжлалт анагаах ухаан, нүүр ам, хүний их эмч, эм зүйч нар жилд 6 багц цаг, сувилагч, тусгай мэргэжилтэн жилд 3 багц цагийн сургалтад хамрагдахаар заасан байна. Эмнэлгийн мэргэжилтэн тасралтгүй сургалт буюу багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдсанаар зөвшөөрлийг сунгуулна. Эмнэлгийн мэргэжилтний жил тутамд биелүүлэх багц цагийн 2/3-оос доошгүй нь тухайн ажиллаж байгаа мэргэжлийн чиглэлээр, бусад нь ёс зүй, харилцаа хандлага, хууль эрх зүй, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр байна гэж заасан. Багц цагийн сургалтын кредит тооцох аргачлалын хувьд 1 багц цаг нь лекцийн 12, дадлагын 24 цагтай тус тус дүйцнэ гэж заасан нь лекцийн цаг нь илүү багц цаг олгогдохоор заагдсан тул сургалт зохион байгуулагч байгууллагууд энэ хэлбэрийн сургалтыг илүүд үздэг. Угтаа эмнэл зүйн дадлага сургалт нь хүнд мэдлэг, ур чадвар олгоходоо хавьгүй илүү болох нь нотлогдсон тул багц цагийн хувьд дидактик сургалтаас илүү байх ёстой. Зарим сургалт эрхлэх байгууллагын хувьд багц цагийн сургалт бизнес болж хувирснаас аль болох нэг дор олон хүн хамруулж богино хугацаанд сургалт хийхийг зорих болсон. Энэ нь чанаргүй сургалт зохион байгуулах болох үндэс болж байна.

Хоёр. ДЭМБ

ДЭМБ-ээс гаргасан удирдамжид¹ зааснаар тасралтгүй сургалтын тогтолцоог үндэсний хэмжээнд удирдах тогтсон эрх бүхий байгууллага байх ёстой ба тасралтгүй сургалтын үйл ажиллагаатай шууд холбоогүй байх хэрэгтэй гэж тусгасан байдаг. Эрх бүхий байгууллага нь магадлан итгэмжлэлийн хүрээнд холбогдох дүрэм журмыг боловсруулах, удирдамжийг гаргах үүрэгтэй.

Магадлан итгэмжлэлийг олгох, сунгах, цуцлах шийдвэрүүдийг гаргах, кредит бүрдүүлэлт, урамшуулал олгох асуудлыг хариуцна. Мөн гомдол саналыг хүлээж авах хороо болон зорилгоо хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад хороог байгуулна.

2.1. Байгууллагын бүтэц

2.1.1. Эрх бүхий байгууллага

Эрх бүхий байгууллага нь үндэсний эрүүл мэндийн зөвлөл, эсхүл эрүүл мэндийн зөвлөл байхгүй тохиолдолд эрх бүхий байгууллагаас байгуулагдсан бусад байгууллага болох эрдэм шинжилгээний байгууллага / мэргэжлийн зөвлөл, үндэсний мэргэжлийн холбоо, яамд, олон нийтийн төлөөлөл гэх мэт оролцогч талуудаас зохих төлөөлөлтэй байж болно. Дараах зөвлөл буюу хороод хамтран ажиллана:

2.1.1.1. Удирдах зөвлөл: Эрүүл мэндийн зөвлөл / улсын эрх бүхий байгууллага нь даргаа томилох ба оролцогч талуудын бүлгээс тус бүр нэг төлөөлөгч томилно. Чиг үүрэг: Энэ нь тасралтгүй сургалтын системийг удирдах дээд түвшний шийдвэр гаргах байгууллага байх болно.

2.1.1.2. Боловсрол, шинжлэх ухааны хороо: *Чиг үүрэг:* Энэ хороо нь тасралтгүй сургалт эрхлэгч байгууллагуудын дагаж мөрдөх удирдамжийг боловсруулна. Эрдмийн / боловсролын хороо нь удирдах зөвлөл болон дэд хороотой зөвшилцөн голлох үр дүнгийн үзүүлэлтүүд болох ур чадвар, сургалтын агуулга чиглэлийг хэрэгцээнд үндэслэн санал

болгоно. Хороо нь тасралтгүй сургалтын үнэлгээний журам, давтамж, шаардлагатай кредитын хэмжээ, кредитыг хэрхэн тооцох, шилжүүлэх зэргийг удирдах байгууллагад батлуулахаар санал болгоно.

Цаашлаад тус хороо нь тасралтгүй сургалтын хүртээмж, хүртээмжийг хангах стратегийг тухайн улсын бүх шатны эмнэлгийн эмч нарт санал болгодог. Энэ нь алсын зайн сургалт, мэдээллийн технологи, онлайн сургалт, телемедицин зэрэг зохих технологийг ашиглахыг тодорхойлж, ашиглахыг зөвлөдөг.

Мөн энэхүү хороо нь удирдах байгууллагад үнэлгээний системийг батлуулахаар санал болгодог. Үнэлгээний ийм системд бүртгэлийн дэвтэр, портфолио, онлайн үнэлгээ, өөрийгөө үнэлэх зэрэг олон арга, хэрэгсэл орно.


Боловсролын хороо нь тасралтгүй сургалтын хөтөлбөрийг улс орондоо болон гадаадад түгээн дэлгэрүүлэх, ашиглах зорилгоор хамтран ажиллах, хамтын ажиллагаа, харилцан ашигтай байх чиглэлээр дэд хороо байгуулж болно. Тус хороо нь цаашдын хөтөлбөрийг хөнгөвчлөх, сайжруулах зорилгоор тасралтгүй сургалтын хөтөлбөрийн багш, оролцогчдын бүртгэлийг хөтлөнө.

2.1.1.3. Үнэлгээний хороо: Хороо нь удирдах зөвлөлөөс нэр дэвшүүлсэн гишүүдээс бүрдэнэ. *Чиг үүрэг:* Энэхүү хороо нь тасралтгүй сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, кредит олголт, урамшуулал болон хариуцлагын талаарх бодлогын санал боловсруулж удирдах зөвлөлд танилцуулна. Урьдчилан боловсруулсан бодлогын удирдамж, саналын дагуу тасралтгүй сургалтын гол холбоос болох лиценз сунгалтын талаар зөвлөмж гаргана. Удирдамж урьдчилан боловсруулна. Боловсруулсан бодлогын удирдамжийн дагуу гүйцэтгэх хороонд сунгахтай холбоотойгоор тасралтгүй сургалтын талаархи санал, бодлогыг олгох талаар зөвлөмж гаргана.

2.1.1.4. Харилцаа холбооны хороо: Хороо нь удирдах зөвлөлөөс нэр дэвшүүлсэн гишүүдээс бүрдэнэ. *Чиг үүрэг:* Энэхүү хороо нь тухайн орны онцлогт нийцсэн хамгийн сайн туршлага, хэрэгцээ шаардлагыг үндэслэж үндэсний түвшинд болон бүс нутаг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудын хамтын ажиллагааг хангаж ажиллах юм.

Хамтын ажиллагаа нь тус улсын их сургуулиуд, эрүүл мэндийн салбар дахь мэргэжлийн холбоод, нийгэмлэгүүд болон ДЭМБ, Эрүүл мэндийн боловсролын дэлхийн холбоо /WFME/ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах болно.

Тус хороо нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр эмч нарт тасралтгүй сургалт шаардлагатай байгаа талаар сурталчлан таниулах ажлыг хийж гүйцэтгэх ба удирдах зөвлөлөөр батлуулах стратегийг боловсруулна.



Гурав. Тасралтгүй сургалтын талаарх олон улсын туршлага

3.1. Магадлан итгэмжлэх зөвлөл

Олон улсад эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд лицензээ сунгуулахад тасралтгүй сургалтанд суусан байхыг шаарддаг. Сургалт эрхлэх байгууллагуудад эрх олгох зөвшөөрлийг АНУ-ын хувьд Эмнэлгийн тасралтгүй боловсролын магадлан итгэмжлэх зөвлөл (ACCME), Америкийн остеопатик нийгэмлэг (AOA) зохицуулдаг бол Канадад Royal College of Physicians and Surgeons of Canada (RCPSC) болон College of Family Physicians Canada (CFPC) байгууллагууд олгодог. Энэхүү байгууллагуудын ялгаа нь эмч мэргэжилтнүүдийг мэргэшлийн чиглэлийн дагуу буюу өрхийн анагаах ухаан болон бусад төрөлжсөн мэргэжил тус бүрээр ялган, тасралтгүй сургалтанд хамрагдсан эсэхийг хянах, сургалт эрхлэх байгууллагуудад магадлан итгэмжлэл олгодоггоороо онцлогтой.

3.2. Кредит цуглуулалт

Төрөлжсөн мэргэжлийн эмч нар (Канад улсад) мэдлэг, ур чадвар, гүйцэтгэлээ сайжруулахын тулд гэрчилгээ олгох хөтөлбөрт хамрагдсан байх ёстой. Таван жилийн хугацаанд эмч нар 400 кредитийг цуглуулж баримтжуулах шаардлагатай бөгөөд жил тутамд дор хаяж 40 кредит авсан байна. Сургалтын үйл ажиллагааны төрлөөс хамаарч нэгээс хоёр кредит олгогддог. Харин өрхийн эмч нар нь таван жилийн хугацаанд 250 кредит цагийг биелүүлсэн байхыг шаарддаг. Жил тутамд 50 кредит авах ёстой. Эмч нар тасралтгүй сургалтаа баталгаажуулахын тулд тухайн сургалтын жилийн турш нэмэлтээр 24 цагийн илүү дээд түвшний сургалтанд хамрагдах шаардлагатай болдог.

ОХУ-д мэргэжлийн ур чадвараа тасралтгүй сайжруулах, мэргэшлийг өргөжүүлэх, магадлан итгэмжлэлд хамрагдахын тулд эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд жилд 50 академик цаг 1 жилийн сургалтаар, таван жилийн хугацаанд дор хаяж 250 академик цагийг тасралтгүй сургалтаас бүрдүүлнэ. Эмнэлгийн мэргэжилтнүүд 1 жилд тасралтгүй боловсролын хөтөлбөрт хамгийн багадаа 36 буюу түүнээс дээш цагийг албан ёсны боловсролын үйл ажиллагаанд, 14 цагийг боловсролын интерактив модуль буюу өөрөө бие дааж суралцах, арга хэмжээ, хурал цуглаанд оролцох зэргээр цуглуулдаг байна.

Харин Япон улсад эмчийн эмчлэх эрхийн лиценз нь хугацаагүйгээр олгогддог ба төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нар 5 жилд 50 кредитийн тасралтгүй сургалтанд хамрагдаж багц цагаа бүрдүүлсэн байх ёстой байдаг.

50 кредит бүрдүүлэлт нь

- 30 кредит нь нарийн мэргэжлийн дагуу
- 10 кредит нь мэргэжил хамаарахгүй заавал судлах ёстой хичээлүүд. Үүнд: эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, халдвар хамгаалалт, ёс зүйн сургалтууд багтана.
- 10 кредит нь эрдэм шинжилгээний ажилд оролцсон байх (1-р зохиогч бол 2 кредит, хамтарсан бол 1 кредит гэх мэт журмын дагуу). Мөн тухайн судалгааны ажлыг заавал нийгэмлэгээрээ зөвшөөрүүлсэн байх зэрэг шаардлага тавьдаг байна.

3.3. Сургалт эрхлэгч байгууллага

Эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтын үйл ажиллагааг төрөл бүрийн байгууллагууд хариуцан, тохирсон хөтөлбөр боловсруулж, сургалтыг зохион байгуулдаг. Үүнд:

- Мэргэжлийн холбоод
- Анагаахын боловсролын агентлагууд
- Эмнэлэгүүд

- Боловсролын байгууллагууд, түүний дотор их дээд сургууль, анагаах ухаан, сувилахуйн сургууль
- Гэрийн сувиллын тасралтгүй сургалтын үйлчилгээ эрхлэгчид

3.4. Олон улсад сургалт хэрхэн явагддаг талаар:

АНУ-ын томоохон их сургуулиудын нэг болох Стэнфордын Их сургууль тасралтгүй сургалтыг ²онлайн хэлбэрээр болон хурал зөвөлгөөн зохион байгуулах зэргээр явуулдаг. Онлайн сургалтын давуу тал нь суралцагч орон зай, цаг хугацаанаас үл хамааран байгаа газраасаа хүссэн цагтаа интернэтэд холбогдон сургалтуудыг авах боломжтой. Онлайн сургалтын бас нэгэн давуу тал нь сургалтад хамрагдах гэж хөдөө орон нутгаас ирэх тээврийн зардал, хотод байрлах зардал зэрэг суралцагчаас гарах зардлуудыг хэмнэж өгдөг.

3.4.1. Сургалтын хэлбэр:

- Онлайн сургалт
- вебинар буюу интернэтэд суурилсан сургалт
- хурал зөвлөгөөн зохион байгуулах
- эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, өгүүлэлд үнэлгээ өгөх
- E материал - E материалыг гаргахдаа боловсруулж гаргасан он болон хүчингүй болох хугацааг тодорхой зааж өгдөг. Ингэснээрээ материал хуучрах буюу мэдээлэл хоцрогдох асуудал үүсэхгүй бөгөөд цаашлаад шинжлэх ухааны шинэ арга барилыг цаг алдалгүй нэвтрүүлж материалаа шинэчлэх нөхцлийг бүрдүүлдэг.
- Гардан үйлдлийн гүйцэтгэлийг сайжруулах сургалтууд- 3 үе шаттайгаар явагддаг, тодорхой гардан үйлдлийг хийх зааварыг авч, тухайн гардан үйлдлийг давтан хийж, эцсийн шатанд өөрийн биеэр хийж үзүүлсэнээр үнэлэгдэнэ.
- Physician RSS- тогтсон хуваарьт сургалтууд

3.4.2. Интернэтэд суурилсан вебинар сургалтууд тодорхой өдөр болон тодорхой цагт шууд явагддагаараа онцлогтой. Мэндчилгээ, танилцуулгаар эхэлж цаашлаад сургалт явагдаж, панел хэлэлцүүлэг буюу асуулт хариултын хэсгээр үргэлжилдэг. Сургалтыг удирдаж явуулах сургагч багш нарын мэдээллийг тодорхой оруулж өгдөг ба ямар нэгэн ашиг сонирхолтой (эмийн компани спонсорлосон г.мэт) холбоотой эсэхийг мөн оруулж өгдөг. Эдгээр вебинар сургалтуудыг сайт буюу цахим хуудас дээрээ хадгалан, дараа дараагийн суралцагсадад мэдээлэл өгөх, суралцах, мэдлэг чадвараа дээшлүүлэх боломжийг олгодог.


3.4.3. Эрдэм шинжилгээний өгүүлэл-ийг уншиж ойлгон өөрийн болгож үнэлгээ авах байдлаар кредит цагаа тооцуулж болдог. Ингэхдээ тухайн эрдэм шинжилгээний өгүүллийг уншиж, танилцан курсийн төгсгөлд асуултад хариулах замаар буюу тестийн аргаар үнэлгээг нь авдаг.

3.4.4. Хурал зөвөлгөөн зохион байгуулах- сайт буюу цахим хуудас дээрээ хурал, зөвөлгөөний талаар дэлгэрэнгүй мэдээллийг байршуулж өгдөг. Сургалтын дэлгэрэнгүй хөтөлбөр, хэзээ, хаана явагдах, аль тэнхимээс зохион байгуулж байгаа, сургагч багш нарын мэдээлэл, хэрэгцээтэй байдал, зорилтот бүлэг- жишээ нь: өрхийн эмч болон уушигны эмч,

бага эмч, сувилагч болон бусад эмнэлгийн мэргэжилтэн гэх зэргээр зорилтот бүлгээ тодорхойлдог, цаашлаад зорилго, магадлан итгэмжлэгдсэн байдал, сургалтын төлбөр зэрэг мэдээллүүдийг тусгаж өгдөг.

3.4.5. Судалгааны өгүүллийн тойм судлах /Manuscript review/- сэтгүүлд хэвлэн нийтлэхээс өмнө өгүүллийг хянан шалгаж, шүүмж хийж судалгааны давуу болон дутагдалтай талыг судлахад оролцдог үйл ажиллагаа юм.

3.4.6 Тогтсон хуваарьт сургалт (Regularly scheduled series)- тогтсон хуваарьт сургалт нь долоо хоног бүр, сар бүр, эсвэл улирал тутамд санал болгодог, тасралтгүй үргэлжлэн хийгддэг, цуврал байдлаар явуулж буй сургалтын үйл ажиллагаа юм.. Жишээлбэл: эмнэлгийн тойролт, эмч нарын зөвөлгөөн, хурал семинар. Тогтсон хуваарьт сургалтууд нь эмнэлгийн тойролт, тохиолдолд суурилсан хэлэлцүүлэг, журнал клуб болон вебинар хэлбэрээр явагдаж болдог.



Тасралтгүй сургалтаар дор хаяж нэг мэргэжлийн практик цоорхойг гаргаж ирэх³

Дөрөв. Дүгнэлт

Эмч нар, эмнэлгийн мэргэжилтнүүд нь хурдацтайгаар шинэчлэгдэн өөрчлөгдөж буй эрүүл мэндийн салбарт өөрийгөө тасралтгүй хөгжүүлж сурч боловсрон шинэ технологийг эмчилгээ оношлогоо, тусламж үйлчилгээндээ нэвтрүүлэх шаардлагатай тулгарч байна. Магадлан итгэмжлэгдсэн анагаахын тасралтгүй сургалт нь эмч, эмнэлгийн ажилчдыг хөгжүүлэх гол түлхүүр болоод байна. Эмнэл зүйн төдийгүй тусламж үйлчилгээг зохион байгуулах мэдлэг, ур чадвар, оролцоог дээшлүүлсэн анагаахын тасралтгүй сургалтанд заавал хамрагдах нь олон улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө сунгуулах нэг үндэслэл болдог

Тасралтгүй сургалтын тогтолцоо нь олон улсад өөр өөр байгаа хэдий ч нийтлэг зүйлстэй. Сургалт эрхлэх байгууллагууд нь зайлшгүй тухайн улсын магадлан итгэмжлэх зөвлөлөөр итгэмжлэгдсэн байна. Зөвлөл нь ихэвчлэн төрийн бус байгууллага байдаг хэдий ч засгийн газартай нягт холбоотой хамтран ажилладаг. Энэхүү зөвлөл нь цааш сургалт эрхлэгч байгууллагуудын ангилалын дагуу буюу анагаахын мэргэжлийн холбоод болон анагаахын сургууль, сувилахуйн сургууь зэрэгт магадлан итгэмжлэл олгосноор үйл ажиллагаа нь үргэлжилдэг.

Олон улсад Монгол улстай харьцуулахад сургалтын олон хэлбэрүүдийг явуулж, сургалтын чанар, баталгаажилт дээр ихээхэн анхаарч байна. Сургалтын олон хэлбэрүүдийг сонгосноор тасралтгүй сургалтыг илүү үр дүнтэй явуулах боломж бүрддэг байна. Голчлон онлайн сургалт дээр тулгуурлаж явж буй нь суралцагчид орон зай, цаг хугацаанаас үл хамааран сургалтад хамрагдаж кредитээ бүрдүүлэх боломжийг олгож байна. Онлайн сургалт нь алслагдсан бүс нутагтай тархай бутархай хүн амтай оронд илүү зохимжтой, зардал хэмнэсэн, асуудалд суурилсан тул дэлхий дахинд ихээр хэрэглэж буйн нэг шинж юм. Сургалтын шинэлэг тал, давуу тал, юу сурсан байх, хэн заах, эмч нарын бүрэлдэхүүн зэрэг шаардлагатай мэдээллүүдийн тусгах нь өндөр ач холбогдолтой байна. Мөн зарим их сургуулиуд тэнхимээр олгогдсон сургалтын видео бичлэгийг хадгалан, өөр хүмүүс дахин үзэх боломжтойгоор оруулж байгаа нь бас нэгэн давуу тал болж байна.

Эх сурвалж:

¹ Regional Guidelines for Continuing Medical Education (CME)/ Continuing Professional Development (CPD) Activities WHO Regional Office of South East Asia 2010

² Stanford Center for Continuing Medical Education <https://stanford.cloud-cme.com/default.aspx>

³ CME Training manual

https://www.beaumont.edu/docs/librariesprovider2/continuing-medical-education/rss-training-manual-resource-guide.pdf?sfvrsn=3e624def_2